



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНХИМ

“Экономиксийн цагаан толгойг хэн сайн мэдэх вэ?”

Улсын XVIII олимпиадын удирдамж

Зорилго:

Эдийн засаг, бизнесийн удирдлагын чиглэлээр их, дээд сургуульд суралцдаг 1-р түвшний оюутнуудын экономиксийн мэдлэг чадвар, авхаалж самбааг сорих, мэдээлэл солилцох, экономиксийг гүнзгийрүүлэн судлах сонирхлыг дэмжихэд оршино.

Оролцогч:

Монгол улсын эдийн засаг, бизнесийн удирдлагын чиглэлээр бакалаврын сургалт явуулдаг их, дээд сургуулиудын эдийн засгийн онолын суурь мэдлэг олгох хичээлийг судалсан болон судалж буй 1-р түвшний оюутнууд оролцох эрхтэй. Оюутнууд 3 гишүүнтэй баг бүрдүүлж оролцох ба баг бүр оноосон нэртэй байна. Анги, хөтөлбөр харгалзахгүйгээр салбар сургуулиасаа багаа бүрдүүлж болно.

Шагнал:

Багийн дүнгээр: I байр 1, Өргөмжлөл, 500,000 төгрөг
II байр 1, Өргөмжлөл, 300,000 төгрөг
III байр 1, Өргөмжлөл, 200,000 төгрөг

Хувийн дүнгээр: I байр 1, Өргөмжлөл, 200,000 төгрөг
II байр 1, Өргөмжлөл, 100,000 төгрөг
III байр 2, Өргөмжлөл, 50,000 төгрөг
Тусгай байр 3, Өргөмжлөл, дурсгалын зүйл

Олимпиадын үе шат:

Олимпиад 2 үе шаттай явагдана.

I үе шат:

2025 оны 5-р сарын 3-ний өдөр МУИС-ийн хичээлийн IV ба V байранд явагдана. Оролцогчдын микроэкономикс болон макроэкономиксийн суурь мэдлэгийг тестээр шалгана. Багуудыг гишүүдийн авсан онооны нийлбэрээр байр эзлүүлнэ.

I шатны хөтөлбөр:

09:00-10:00 Бүртгэл баталгаажуулна. Багийн бүх гишүүд **иргэний үнэмлэх** болон **оюутны үнэмлэхийг** заавал авчирна. (Хэрэв бичиг баримтууд авчирах боломжгүй бол e-mongolia-н иргэний үнэмлэхний тодорхойлолт болон сургуулийн тодорхойлолт авч ирж болно.) Аль нэг бичиг баримт дутуу бол олимпиадад оролцуулахгүйг анхаарна уу!

10:00-10:30 Нээлт
10:30-12:30 Шалгалт
12:30-14:00 Дүн гаргах
14:00-15:00 Дүн танилцуулах

II үе шат

2025 оны 5-р сарын 10-ны өдөр явагдана. Эхний шатнаас шалгарсан хамгийн өндөр оноотой 10 баг II шатанд бодлого бодох, асуудал шийдвэрлэх даалгавар гүйцэтгэнэ.

Хамрах сэдэв:

1. Микроэкономиксийн үндэс:

- Эдийн засгийн үндсэн зарчим, судалгааны арга болон суурь загварууд
- Эрэлт ба нийлүүлэлт, тэдгээрт нөлөөлдөг хүчин зүйлсийн шинжилгээ
- Зах зээлийн тэнцвэр, тэнцвэрийн өөрчлөлт,
- Зах зээлийн үр ашиг, түүний өөрчлөлт, татвар ба татаас
- Эрэлт ба нийлүүлэлтийн мэдрэмжүүд, түүний хэрэглээ
- Үйлдвэрлэлийн онол: үйлдвэрлэл ба орлого
- Богино ба урт хугацааны зардлууд, тэдгээрийн хамаарал
- Зах зээлийн өрсөлдөөний хэлбэрүүд (төгс ба төгс бус өрсөлдөөнт зах зээл)
- Зах зээлийн сул тал, түүнтэй холбоотой асуудлууд
- Үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн зах зээл, монополь ба монополи

2. Макроэкономиксийн үндэс:

- Үндэсний эдийн засгийн үзүүлэлтүүд, тэдгээрийн тооцоолол
- Нийт эрэлт, нийт нийлүүлэлт, эдийн засгийн богино ба урт хугацааны тэнцвэр
- Эдийн засгийн хэлбэлзэл, бизнесийн мөчлөг
- Эдийн засгийн өсөлт, өсөлтийг тодорхойлох хүчин зүйлс
- Ажилгүйдэл ба инфляци, тэдгээрийн хамаарал
- Сангийн болон мөнгөний бодлого, тэдгээрийн үр нөлөө
- Олон улсын худалдаа, туйлын болон харьцангуй давуу тал

Бүртгэл

Олимпиадад оролцох багууд 2025 оны 4-р сарын 16-27-ны хооронд цахимаар бүртгүүлнэ. Цахим бүртгэлийн холбоосыг

- <http://dep.num.edu.mn/econ/>
- <https://www.facebook.com/economicsatnum> -д тухайн үед нийтэлнэ.

Цахим бүртгэлийг багийн төлөөлөл зөвхөн нэг удаа бөглөнө.

Бүртгэлийн хураамж багийн 15,000 төгрөгийг ХААН Банк 5062059999 (Эрдэнэбулган Дамдинсүрэн) дансанд тушааснаар бүртгэл баталгаажина. Гүйлгээний утга дээр багийн нэр, холбоо барих утасны дугаарыг бичсэн байна.

Холбоо барих:

dulbadrakh@num.edu.mn, 80098596
erdenebulgan.d@num.edu.mn, 99108513